

Татварын боловсрол төсвийн тогтвортой байдалд нөлөөлөх нь

The Role of Tax education in Maintaining a Sustainable Fiscal Position

Г. Алтанзаяа¹, Х. Тунгалагмаа²

Хураангуй

Татварын боловсрол нь татварын хуулийг дагаж мөрдөх зан үйлийг хөхүүлэн дэмжих төрийн болон төрийн бус байгууллагуудын хөтөлбөрүүд, бизнесийн байгууллагуудын татварын асуудлаарх нийгмийн хариуцлагын ажлууд гэсэн бүх нийтийн хүчин чармайлт, иргэний нийгмийн санаачлагууд зэрэг олон төрлийн үйл ажиллагааг хамардаг. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-аас хийгдсэн сүүлийн үеийн судалгаанууд нь татварын ёс суртахуун - иргэдийн төлсөн татвар болон нийгмийн зардлын санхүүжилтийн талаарх ойлголт хоорондоо уялдаа холбоотой болохыг харуулж, сайн засаглал бүхий чанартай төрийн үйлчилгээ авч байгаа хүмүүс татвараа төлөх хүсэл эрмэлзэлтэй болдог гэж үзжээ. Энэхүү ажлын зорилго нь татварын боловсролын хүрээний онол, үзэл баримтлал, түүний хэрэгцээ, татварын ёс суртахуун, соёл болон төсвийн тогтвортой байдлын үндэс суурь болохыг судлах ба татварын боловсрол олгох чиг хандлагыг тодорхойлоход оршино.

Түлхүүр үгс: татварын мэдлэг, татварын боловсрол, татварын соёл, татварын ёс суртахуун

Abstract

Tax education covers a wide range of activities, including government and non-government programs to promote compliance with tax laws, corporate social responsibility for tax issues, and civil society initiatives. Recent research by the Organization for Economic Co-operation and Development (OECD) has shown that there is a link between tax ethics - the concept of taxes paid by citizens and the financing of social expenditures, and that well-governed people are willing to pay taxes. The purpose of this paper is to examine the theory and concept of tax education, its needs, the basis of tax ethics, culture and fiscal sustainability, and to identify trends in tax education.

Keywords: tax knowledge, tax education, tax culture, tax ethics

¹ Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн ерөнхийлөгч, Доктор (Ph.D)

E-mail: altanzaya99@gmail.com

² Монголтакс ТМЗ ХХК

E-mail: tungalagmaa@gmail.com

Татвараа өөрөө тодорхойлон төлөх тогтолцоо - татварын ёс суртахуун, соёлын тухай

Улс орон тэнцвэртэй, тогтвортой, бас орлоготой хөгжих ёстой ба ямарч улсын тогтвортой хөгжих байдлыг зөв татварын бодлого, татвараа хураах зөв удирдлага механизм хангана. Ямар ч засгийн газар татварын орлогоо дотооддоо төвлөрүүлэхийг эрмэлзэж төсвийн болон татварын хууль тогтоомжийг баталж мөрддөг.

Иргэд татвар төлөх нь өөрсдийнхөө засгийн газартай харилцах харилцааны салшгүй хэсэг гэж үзэх эрх, үүрэгт суурилсан нийтээр хуулийг дагаж мөрдөх татварын соёлыг төлөвшүүлэх нь татварын боловсролд анхаарахад хүргэнэ. Татвар төлөгчдөд татварын боловсрол олгох үйл явц нь татварын алба, иргэдийг холбох гүүр бөгөөд татварын соёлыг төлөвшүүлэх гол хэрэгсэл ба төсвийн татварын орлого хэдий хэмжээгээр бүрдэнэ төдий хэмжээгээр улс орны тогтвортой хөгжих үндэс суурь нь юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 17.1.3-д хуулиар ногдуулсан албан татвар төлөх”, ТӨХ-ийн хуулийн 28.1.Татвар төлөгч холбогдох татварын хуулиар төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлж, хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төлнө гэж заасан байдаг.

Ногдох татвараа өөрөө тодорхойлон төлөх гэдэг нь зөвхөн төлдөг бус хуулийн дагуу ямар хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх, татварын харилцааны зохицуулалтаас ямар өгөөж хүртэхээр байна түүнийгээ хүртэх замаар татварын буцаан олголтоо авах механизм ажээ.

Татвараа өөрөө тодорхойлон төлөх систем

гэдэг нь татвар төлөгч татварын хуулийн дагуу өөрөө татвараа тодорхойлон төлөх, тайлагнах үйлдэл (Palil, 2010) гэж тодорхойлсон байна.

Татварын ёс суртахуун


Татварын ёс суртахуун нь татварын хуулийг дагаж мөрдөх шийдвэрийн чухал бүрэлдэхүүн хэсэг ба татварын хуулийг дагаж мөрдөх нь хэчнээн чухал вэ гэдэгт хариулт болон байгалиас заяагдмал байдлаар урган гардаг ажээ. Энэ нь хуулийг дагаж мөрдөх, үгүй эсэхэд хүн төрөлхтний ёс суртахуун гол хүчин зүйл болдог уу, эсвэл зөвхөн гаж нөлөө үзүүлэх үед л гардаг зүйл үү? гэсэн асуулт дагалдаж байна. Татварын ёс суртахууны талаарх ойлголт нь татвараас зайлсхийх, хуулийн хэрэгжилт хангагдахгүй үед ихэвчлэн урган гардаг нь судалгаагаар тогтоожээ (Global Tax Advisers Platform, 2019).

Татварын ёс суртахуун сул байх нь иргэдийн нийтлэг нийгэмдээ хандах эрмэлзлийг сулруулаад зогсохгүй татвараас зайлсхийх рүү түлхдэг, тэд энэ шалтгаанаа төрийн шударга бус татварын бодлого, нийгмийн хандлагын гажуудал, татварын мэдлэггүй гэх үндэслэлээр зөвтгөдөг ажээ. Татвар төлөгчдийн боловсролын үйл ажиллагааг тэргүүлэх чиглэл гэж үзэх хандлага руу эрх баригчид чиглэхгүй байх нь олон улсын татварын шинэчлэлд нийцэх үйл ажиллагаагаа орхигдуулж буй хэрэг болно.

Татварын соёл

Олон орны татварын удирдлагад тулгардаг асуудал нь хууль тогтоомжид заасны дагуу татвараа бүрэн цуглуулж чаддаггүй явдал юм. Үүний үндсэн шалтгаан нь “татварын соёл” гэж үзэж иржээ. Татварын соёлын үзэл баримтлал татвараас зайлсхийх,

Зураг 1. Татвар ногдуулалтын соёл



Эх сурвалж: Chuenjit (2014)

татвараас зугтах, татварын хуулийг дагаж мөрдөх, татварын ёс суртахуун зэрэг нэр томъёонуудтай нягт холбоотой юм (Chuenjit, 2014).

Татварын соёл нь татвар төлөгчид, татвар хураагч нар татварын тогтолцоо ба эсэргүүцэх бүхий л зан үйлийн хэв маягийг агуулдаг. Татварын соёл нь татвар төлөгч, татвар хураагчдын итгэл үнэмшил, бусад хүмүүсийн нөлөөнд автах бүлэг бүрийн үйлдлийг хамарч байгааг Зураг 1 харуулж байна.

Татвараа өөрөө тодорхойлон төлөх тогтолцооны хэрэгжилтийн байдал

Татвараа өөрөө тодорхойлон төлөх систем нь хуулийг хэний ч шахалтгүй сайн дурын үндсэнд сахин биелүүлэх агуулгыг илэрхийлнэ. Сайн дурын үндсэнд татварын хуулийг сахин биелүүлж, өөрөө тодорхойлон төлөх, Татвараа өөрөө тодорхойлон төлөх эсэх нь сайн дурын хэрэг, эсвэл хэрэгжүүлэхгүй ч байж болох гэсэн асуудал нь татвар төлөх нийгмийн сэтгэлгээний хандлагыг илэрхийлнэ.

ХХОАТ-ын тухай хуулиар татвар ногдох орлоготой иргэд тайлан гаргаж татвараа төлөхөөр зохицуулсан байдаг. Монгол улсад өнөөгийн байдлаар нийт 1.3 сая (www.1212.mn) орчим иргэн эдийн засгийн

идэвхитэй хүн амд хамрагдаж байна. Иргэн хөдөлмөр эрхлэхээс гадна үйл ажиллагаа эрхэлж орлого олох боломжтой ба хуулийн этгээд байгуулахгүйгээр хувиараа бизнес эрхэлж буй иргэдийн тоо 250,000 орчим байгаа гэсэн тооцоо яригддаг. Харин ХХОАТ-ын тухай хуулийн дагуу төсөвт орж буй орлогын 89-98 хувийг цалин хөлснөөс суутгасан татвар эзэлж буйг Хүснэгт 1-т харуулж байна. Хувь хүн орон сууц, их дээд сургуулийн сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдлэхээс бусад тохиолдолд татварын тайлан гаргах шаардлагагүй мэт ойлголттой явж ирсэн.

2021 оны 3-р сарын байдлаар 210,756 (www.burtgel.mn) хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгэлтэй байна. Эдгээр нь ААНОАТ-ын тайлан гаргаж тушаах үүрэгтэй ажээ. Үйл ажиллагаа эрхэлж буй 93,858 (www.1212.mn) аж ахуйн нэгж гэсэн мэдээ байна. Татварын албаны 2018 оны мэдээгээр 94.0 мянган (58 хувь) хуулийн этгээд татварын тайлан гаргаж тушаасан ба үүний 9.9% нь алдагдалтай, 24.5% нь Х (үйл ажиллагаа явуулаагүй) тайлан, 23.4% нь татвар ногдох орлоготой тайлагнасан байна. Харин нийт хуулийн этгээдийн 42 хувь нь татварын тайлангаа гаргаж тушаагаагүй бөгөөд жил ирэх бүр энэ тоо өсөх хандлагатай явж иржээ.

Хүснэгт 1. Татварын орлого дахь орлогын албан татвар

Нэр төрөл	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Татварын орлого	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
Орлогын албан татвар	32.1	36.3	22.8	20.4	21.5	21.3	22.9	21.1	25.5	25.4	26.1	18.7
Орлогын албан татвар	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
Үүнээс: ААНОАТ	61.6	70.8	70.1	61.0	60.5	56.4	58.8	49.8	59.8	61.2	65.2	51.0
ХХОАТ	38.4	29.2	29.9	39.0	39.5	43.6	41.2	50.2	40.2	39.8	34.8	49.0
Үүнээс: цалин хөлс	89.4	92.9	93.0	98.0	94.0	92.1	94.0	93.0	89.0	90.0	89.0	

Эх сурвалж: www.1212.mn

Татварын хуульд зааснаар иргэн, аж ахуйн нэгж бүр албан татвар ногдох орлогоо тайлагнаж, холбогдох татварыг төлөх үүрэгтэй хэдий ч өнгөрсөн 30 орчим жилийн хугацаанд татвар төлөхөөс зайлсхийх явдал нэмэгдсээр ирсэн бөгөөд хувь хүн татварын тайлан гаргах эсэхэд дийлэнх хүмүүс ойлголтгүй байсаар л байна.

Монгол Улсын татвар төлөх үүргийн байдлыг илүү тодотгохын тулд орлогын албан татварын төрөл, зүйлээр татварын орлогод эзлэх үүргийг Хүснэгт 1-т харуулав.

Энэ хүснэгтээс харахад Монгол Улсын татварын орлогын 30 орчим хувийг орлогын албан татвар эзэлдэг, энэ нь жилээс жилд буурах хандлагатай ирсэн ба 2017 оноос жаахан өссөн байна. Орлогын албан татварын 50-70 хувийг ААНОАТ эзэлж байна. ХХОАТ-ын 89-98 хувийг цалин хөлснөөс суутгасан татвар эзэлж байгаа нь иргэн өөрөө татвараа тодорхойлон, төлөх үүрэгтэй ч татвар хураалт нь суутганы аргад тулгуурладаг, татвар хураалт ААНОАТ-г илүү чиглэж буйг илтгэж байна.

Татварын хуулийг сахин мөрдөхөд татварын мэдлэгийн үр нөлөө

Нийгмийн татварын соёлыг төлөвшүүлэхэд татвар төлөгчдийн зүгээс татварын хууль

тогтоомжийг дагаж мөрдөх, түүнийг үнэн зөв хэрэгжүүлэх, цаг хугацаандаа төлөх, тайлагнах асуудал чухлаар тавигдана. Татвар төлөгчдийн хувьд татвараа үнэн зөвөөр тодорхойлохгүй, цаг хугацаандаа татвараа төлөх буюу тайлагнахгүй, татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөхгүй байх зэргээр зөрчлүүд гардаг.

Татварын хуулийг сахин мөрдөлтийг үр дүнтэй болох түлхүүр асуудал

Татвараа өөрөө тодорхойлон төлөх системээр татварын хуулийг дагаж мөрдөх, татвар төлөгчдөд үүргээ хэрэгжүүлдэг дадал бий болох, нийгмийн ухамсрыг төлөвшүүлэх, системийг үр дүнтэй байлгах түлхүүр болох дараах 4 зүйл гэдгийг Paliil (2010) өөрийн судалгааны ажилдаа авч үзжээ. Үүнд:

- Татварын боловсрол ба татварын мэдлэг;
- Энгийн, хялбар систем;
- Татварын хяналт шалгалт;
- Алданги, торгууль.

Татвар төлөгч иргэний татварын талаарх мэдлэг олж авдаг судалгаа

Иргэд татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн талаарх мэдээллийг анх 35.6% нь Их, дээд сургуульд сурч байхдаа, 13.3% олон нийтийн мэдээллийн хэрэгслээс, 46.2% нь ажил дээр гараад авсан байна. Татварын хуулийг хэрэгжүүлэхэд учирдаг

асуудлаа шийдвэрлэхэд мэдээлэл авдаг эх сурвалжаар нь авч үзвэл 24.8% нь Татварын алба, татварын лавлах утасруу хандаж; 23.7% нь өөрөө татварын тухай хууль тогтоомжуудыг уншиж судалдаг бол 16.8% нь таньдаг татвар ба нийгмийн даатгалын улсын байцаагчдаас; 9.1% нь татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг мэргэжилтэнд ханддаг бөгөөд үлдсэн 25.6% нь хаана хандах ёстойгоо тодорхой мэдэхгүй гэж хариулжээ. Судалгаанд оролцогчдын 47.7% нь татварын мэдлэг, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим сайт, олон нийтийн сүлжээнээс авдаг гэж хариулж, 31.2% нь цаашид ч энэ талаар мэдлэг мэдээлэл авах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байна.

Татвар төлөгч иргэний татварын хуулийн талаар мэдлэгээ үнэлсэн үнэлгээ
Судалгаанд оролцогчид татварын хуулийн мэдлэгээ дараах байдлаар үнэлсэн байна. Иргэдийн хувьд татвар гэж юу вэ? гэсэн асуултад 51.2% нь төсвийн орлого, 40.7% нь иргэний үүрэг, 3.1% нь дарамт, 5.1% нь татварын талаар ямар нэг ойлголтгүй гэсэн бөгөөд 221 иргэн ХХОАТ төлдөг, 240 иргэн НДШ төлдөг, 11 иргэн мэдэхгүй гэж хариулжээ.

Хувь хүний орлогын албан татварын тайлан (ТТ-06)-г 14.2% нь тогтмол тайлагнаж тушаадаг, 15.3% нь 1-2 удаа, 3.5% нь 3-5 удаа тайлан гаргаж тушаасан гэсэн бол үлдсэн 64.9% нь тайлан гаргаж үзээгүй, энэ тайлангийн талаар мэдэхгүй гэжээ. Үүнээс "Хувь хүний орлогын албан татварын тайлан (ТТ-06)"-г гаргаж байсан шалтгааныг авч үзвэл, судалгаанд оролцогчдын 30.6% нь хуулиар тайлан тушаах үүргийн улмаас; 65.2% нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх

зорилгоор уг тайланг тушаадаг (үүнээс: 30.2% нь орон сууцны хөнгөлөлт эдлэх, 20% нь сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдлэх, 15% нь татварын бусад хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх) гэж хариулсан. Татварын тооцоолол хийж, тайлан тушаахдаа 44.7% нь өөрөө, 34.1% нь татварын байцаагчийн туслалцаатайгаар, 7.8% нь татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээгээр дамжуулдаг байна. Хяналт шалгалтад хамрагдаж акт тавигдсан татвар төлөгчид акт тавигдсан шалтгаанаа 36.5% нь татварын мэдлэг муугаас болсон гэж хариулжээ.

Судалгаанд хамрагдсан иргэд улсын болон орон нутгийн төсөв батлагдах үйл явцад 7.8% нь байнга оролцдог, 6.7% нь орон нутгаас мэдээлэл ирсэн үед оролцдог гэж хариулсан бол 23% нь ямар нэг мэдээлэл харъяа орон нутгийн эрх бүхий байгууллагаас ирдэггүй, 41.5% огт оролцдоггүй гэжээ. Нийт судалгаанд оролцсон татвар төлөгч иргэдийн 84% нь өөрийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн мэдлэг боловсролоо сайжруулах хүсэлтэй гэсэн бөгөөд 62.1% нь иргэдийн татварын боловсролыг сайжруулах зайлшгүй шаардлагатай гэжээ.

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжээс сүүлийн 3 жилийн хугацаанд татвар, нийгмийн даатгалын шалгалтад 58% нь хамрагдсан байна. Үүнээс 62% нь акт, шийдвэрийн хуудас авсан бөгөөд зөрчлийн хувьд 24% нь хууль тогтоомж, дүрэм журмын хэрэглээний зөрчил, 4% нь тооцооллын алдааны улмаас, 16% нь бүртгэлийн алдаанаас, 30.8% нь ойлголтын зөрүүнээс болжээ. Акт тавигдсан дотоод шалтгааныг авч үзвэл 36.5% нь байгууллагын удирдлага болон ажилтнууд татварын мэдлэг, боловсрол

дутмаг, 52.4% нь байгууллагын удирдлага болон нягтлан бодогчийн санамсаргүй алдаа, 9.7% нь санхүү татварын хариуцсан мэргэжилтэн байхгүйн улмаас акт тавигдсан гэж хариулжээ.

Аж ахуйн нэгж, байгууллагаас авсан судалгаагаар татварын хяналт шалгалтад хамрагдсан татвар төлөгчдийн 65-75% нь татварын хууль тогтоомжийг судалж мэдээгүй, нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв хөтлөөгүй, санамсаргүй алдаанаас болж татварын акт, шийтгэврийн хуудас авч байна.

Татварын боловсролыг хөгжүүлэх олон улсын чиг хандлага, практик

Татварын ёс суртахуун ба Татварын суурийг гажуудуулах, ашиг шилжүүлэх (ТСГАШ)-ийн нарийн төвөгтэй байдал

ЭЗХАХБ, ЕХ-ноос татварын сайн засаглалын стандартыг дагаж мөрдөх замаар татварын удирдлагын практикийг хэрэгжүүлэхийг дэмжиж байгаа. Мөн “Татварын алба татвар төлөгчдийн нөөц болон илүү их итгэлцлийн соёлд төвлөрөхөд туслах, бага эрсдэл бүхий компанийн тодорхойгүй байдлыг бууруулах хамтарсан хөтөлбөр”-ийг хамтын ажиллагаагаа хангахаар ОУВС/ЭЗХАХБ-аас батлав (OECD, 2017). Уг хөтөлбөр нь бизнес эрхлэгчдийн дунд татварын ёс суртахууныг бэхжүүлэх, татварын тодорхой байдлыг нэмэгдүүлэх олон талт хэрэгслийг үр дүнтэй болгоход дэмжлэг үзүүлэхийг олон улсын байгууллагуудад уриалжээ.

Хөгжиж буй орнууд ТСГАШ-ийн үр дүнг дэлхийн хэмжээнд хэрэгжүүлэхэд нэгдэж татварын бааз сууриа хамгаалах, олон улсын стандарт, шилдэг туршлагыг тууштай хэрэгжүүлэх замаар хөрөнгө

оруулалтын илүү тодорхой орчныг бүрдүүлэхэд чиглэж байна.

Татвар ба Хөгжлийн хөтөлбөрөөр үнэ шилжилт болон ТСГАШ-тэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд хөгжиж буй орнуудад үзүүлэх дэмжлэгийг олон улсын агентлагуудтай хамтран хэрэгжүүлж байна.

Татвар ба хөгжлийн хөтөлбөрийн ажлын хэсэг 2010 онд байгуулагдсан, 8 удаагийн олон улсын уулзалт зохион байгуулсан ба татварын ёс суртахууны хүрээнд судалгаа хийн (OECD & FIIAPP, 2015) нийтлүүлсэн байна. Уг судалгааны ажилд дэлхийн 28 орны татвар төлөгчдийн боловсролын шинэлэг стратеги, туршлагыг хамарсан дэлхийн мэдээллийн эх сурвалжийг боловсруулж, хөгжиж буй орнуудын татварын албан тушаалтнуудад татвар төлөгчдийн боловсрол, тайлагнах, таниулах стратеги санаа, урам зориг өгөх зорилгоор 2020 онд шинэчлэлт хийн гаргажээ.

Татварын ёс суртахуун нь татвар төлөгчдийн татвар төлөх, төлөхөөс зайлсхийх талаарх ойлголт, хандлагыг хэмждэг. ЭЗХАХБ-ийн энэ арга хэмжээ нь засгийн газрын төлөөлөгчид, тэргүүлэх эрдэмтэн, судлаачид, бүс нутгийн татварын байгууллагууд, бизнес, иргэний нийгмийн байгууллагуудыг олон талт оролцоонд, татварын ёс суртахууны талаар туршлага, сэтгэгдлээ хуваалцаж байгаа ажээ. Татвар төлөх сэтгэл зүйг өдөөж буй зүйл юу вэ? Татварын ёс суртахууныг бид хэрхэн ойлгох вэ? Татварын ёс суртахууныг бий болгох оролдлогуудаас бид ямар сургамж авав? Татварын ёс суртахуунд шинэ технологи ямар үүрэг гүйцэтгэдэг вэ? Бизнес эрхлэгчдийн татварын ёс суртахууныг юу өдөөж байна вэ? Татварын

Хүснэгт 2. Зарим улс орнуудын татварын боловсрол олгох хөтөлбөртэй эсэх

		Австрали	АНУ	Унгар	Канад	Словени	Япон
Татварын боловсрол олгож эхэлдэг нас		10	5	10	10	5	5
Татварын боловсролын хөтөлбөртэй эсэх	Сургуулиас өмнөх насны боловсрол		Тийм			Тийм	Тийм
	Ерөнхий боловсролын сургууль	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм
	Их, дээд сургууль	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм

ёс суртахууныг бий болгоход хөгжлийн түншүүд хэрхэн дэмжлэг үзүүлэх вэ? Татварын ёс суртахууныг төлөвшүүлэхэд иргэний нийгэм ямар үүрэг гүйцэтгэдэг вэ? зэрэг олон асуултад хариулт хайсан судалгааны ажлууд үргэлжилж байна.

Татварын боловсролын талаарх дэлхийн туршлагаас

Дэлхийн улс орнуудын татварын боловсролыг олгох хөтөлбөртэй эсэхийг судлан Хүснэгт 2-т харуулав.

Европын холбооноос TAXEDU дижитал платформыг ажиллуулснаас хойш Үндэсний татвар, гаалийн газрын удирдлага, сургагч багш нар түүнийг сурталчлах, татварын боловсролд ашиглах чиглэлээр ажиллаж байна. Сургалт, эрүүл мэнд, соёлын үндэсний төв зэрэг байгууллагуудаас бага насны суралцагчдад татварын талаар хөгжилтэй, сонирхолтой байдлаар сургах зорилгоор Европын татварын ойлголтыг Хөдөлгөөнт 14 тоглоомтой хослуулан олон нийтэд танилцуулаад байна. TAXEDU платформыг сурталчлах ажлыг багтаасан “Татварын талаарх 2020-2024 оны стратеги”-ийг тодорхойлсон ба оюутан залуучуудад зориулсан сургалтын хөтөлбөрүүд хийгдэж байгаа ажээ. TAXEDU платформ нь бага, дунд сургуулийн суралцагч, багш нарт чиглэсэн гарын авлага, сургалтын хэрэгслээр хангах ба татвар тэдний амьдралд үзүүлэх нөлөөллийн талаар мэдлэг олгох боломжийг олгох зорилготой.


Татварын боловсролыг хөгжүүлэх нь төсвийн тогтвортой байдлыг хангах үндэс болох нь

Татварын боловсролд илүү анхаарал хандуулах нь татвар төлөгчдийн татварын талаарх мэдлэгт эерэг, мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг, татварын мэдлэг нь татварын шударга ёсны байдалд, татварын шударга ёсны байдал нь татварын хуулийн даган мөрдөлтөд (Hofmann нар, 2008), татварын хуулийг даган мөрдөх нь төсвийн татварын орлогод эерэг нөлөө үзүүлэх ба энэ нь төсөв тогтвортой байхад эерэг нөлөө үзүүлнэ. Иймээс татварын боловсролыг хөгжүүлэх, бэхжүүлэх нь татварын мэдлэг бүхий татвар төлөгч, албан хаагчтай институтийг төлөвшүүлэхэд маш чухал үүрэгтэй бөгөөд ингэснээр татварын хуулийг дагаж мөрдөх хандлага бүхий соёл нийгэмд төлөвших боломжтой юм.

Mukhlis нарын (2015) судалгаанд тулгуурлан төсвийн тогтвортой байдалд татварын боловсрол хэрхэн нөлөөлөх загварыг гаргав (Зураг 2).

Энэхүү судалгаа нь татварын боловсрол, татварын мэдлэг, татварын шударга байдал гэсэн хувьсагчуудын хооронд хамаарал татварын хуулийг дагаж мөрдөхөд мэдэгдэхүйц эерэг нөлөөтэй гарснаар төсвийн татварын орлогыг нэмэгдүүлэхэд татварын боловсролын үүрэг, ач холбогдлыг нотолжээ. Татварын өндөр мэдлэг бүхий нийгэм байх тусам олон нийтийн хувьд татварын шударга

Зураг 2. Татварын боловсрол төсвийн тогтвортой байдалд нөлөөлөх нь



ёсны мэдрэмжийг олж авах буюу татварын ёс суртахуунлаг соёл бүрдэхэд чухал нөлөө үзүүлнэ.

Татвар ба Засаглалын хоорондох уялдаа холбоо үнэн хэрэгтээ нэг нь нөгөөдөө амин чухал тул улс орнууд сайн засаглалыг бэхжүүлэхэд татварын шинэчлэлийг дэмжих бодит алхамуудыг хийсээр байна. Энэ бүхний үр дүнд илүү сайн төрийн бодлого гарч татварын ёс суртахуунлаг нийгэм бүрдэх нь төсвийн тогтвортой байдалд эерэг нөлөөлнө.

Татварын боловсролыг хөгжүүлэх ерөнхий хөтөлбөрийн загвар

Татвар төлөгчдийн мэдлэг муу байх нь засгийн газарт хоёр үндсэн шалтгаанаар бэрхшээл учруулдаг. *Нэгт*, татвар төлөгчдийн мэдлэг дутмаг байдгаас татварын хуулийг сахин биелүүлэх түвшин доогуур байна. Татвар төлөгчид татварын тогтолцоог мэдлэггүй, ойлголтгүй байх үед төөрөлдөх, үүргээ хэрэгжүүлэхэд илүү их цаг хугацаа зарцуулах, төвөгтэй байдал нь хариу арга хэмжээ авахад хүргэж болзошгүй байх магадлалтай. Энэ нь шударга бус байдлын талаарх ойлголтыг бий болгож улмаар хуулийг даган мөрдөх

хандлагад сөргөөр нөлөөлдөг. *Хоёрт*, итгэлцэл ба хариуцлага. Сул мэдлэг нь татвар төлөгчдийг татварын талаарх хариуцлага, засаглалыг бэхжүүлэх амин чухал үүргийг сулруулахад хүргэдэг. Татвар төлөгчид татварын үүргийнхээ талаар илүү ихийг мэддэг бол авлига, татварын албан тушаалтнуудын зохисгүй зан авирт өртөх нь харьцангуй бага болох нь судалгаагаар нотлогджээ (Mascagni, 2020). Татвар төлөгчдийн мэдлэгийг практик талаас нь авч үзэх нь авлигыг бууруулж, итгэлцлийг бэхжүүлж, хариуцлагыг сайжруулах болзошгүй хүчин зүйл юм.

Татвар төлөгчдийн мэдлэг сул байгааг засгийн газрууд хэрхэн шийдвэрлэж байна вэ?

Иргэдийг зөвхөн үүрэг гүйцэтгэгч гэхээсээ илүү хамтрагч, холбоотон гэж үзэх болсон. Эдгээр хүчин чармайлт нь татварын алба нь түүхэндээ албадлагын болон дарангуйлагч гэж үзэх бус туслалцаа, үйлчилгээ үзүүлэгч гэх хандлага руу чиглэж байна. Иймээс татварын боловсрол нь нэгдмэл хандлагад үндэслэсэн үндэсний хэмжээнд нэгдсэн арга зүйгээр хэрэгжих хөтөлбөр байх нь зүйтэй гэж үзэж байна.

Татварын боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн ерөнхий загвар

Иргэний ардчилсан хүмүүнлэг нийгэм байгуулна гэдэг нь иргэн нь энэ улс орныхоо эзэн нь байх, төрийн хуулиа сахин биелүүлдэг, төр нь амлалтаа хэрэгжүүлдэг харилцаанд суурилна гэсэн үг. Татварын боловсролыг ирээдүйн татвар төлөгчдийг бэлдэх, татварын чиглэлээр боловсрол олгох, бизнес эрхлэгчдэд мэдлэг олгох, татварын мэргэжилтэнг мэргэшүүлэх гэсэн түвшингээр хөтөлбөр боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх сургалтын гарын авлага, материал бэлтгэх, хэрэгжүүлэх этгээдүүдэд чиг үүрэгт нь суулгах, үр дүнг хариуцах хариуцлагын тогтолцоог бий болгох шаардлагатай юм. Үүнийг хамрах хүрээ, агуулга, хэлбэр талаас нь Хүснэгт 3-т харуулав.

Татварын боловсрол зохих түвшинд олгогдож байгаа ч цаг үеийн шинжтэй, тасралтгүй бус, голдуу хууль хэрэгжүүлэх талаас хандаж байгаа дүр зурагтай өнөө үед нэгдсэн хөтөлбөртэй системтэй тасралтгүй үйл ажиллагаа хэрэгтэй байна. Иймээс татварын боловсрол олгох үзэл баримтлал нь иргэний нийгмийн үнэт зүйл, ардчилсан нийгмийн гишүүн бүрийн эрхэмлэх зүйл, төрийн эрх баригчдын амлалтыг хэмжигч татварын соёлд тулгуурлан нэгдсэн удирдлага дор системтэйгээр хэрэгжүүлэх нь улс орны хөгжилд тустай юм. Үүний тулд татварын боловсролыг үндсэн дөрвөн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үндэсний ерөнхий хөтөлбөрийг боловсруулж санал болгож байна. Ерөнхий хөтөлбөрийг Хүснэгт 4-т харуулав.

Хүснэгт 3. Татварын боловсролын хүрээ, агуулга, хэлбэр

Боловсролын түвшин	Хамрах хүрээ	Агуулга	Хэлбэр
Ирээдүйн татвар төлөгчдийг бэлдэх	Хүүхдүүд (Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын сургууль)	Аав, ээжийн төлсөн татвараар цэцэрлэг, сургууль, эрүүл мэндийн үйлчилгээ авдаг, хэрэглээндээ татвар төлдөг	Хүүхэлдэйн кино, зурагт ном, тоглоом, сурах бичиг, дэвтэр, үзэг зэрэгт татварын албаны лого байх, ахлах ангид та нар ирээдүйн татвар төлөгч гэдгийг мэдүүлэх
Татварын чиглэлээр боловсрол олгох	Коллеж, их, дээд сургуулийн хөтөлбөрт татварын онол, хууль, бүртгэл, тайлагнах асуудлыг тусгах	Татварын онолд тулгуурлан хууль эрх зүйг ойлгох, түүнийг зөв хэрэглэх, бүртгэх, тайлагнах арга зүйн ойлголтыг өгөх	Цахим ба танхимын сургалт Уралдаан, тэмцээн
Бизнес эрхлэгчдэд мэдлэг олгох	Бүх бизнес эрхлэгч, жижиг дунд бизнес эрхлэгчид	Татварын хууль тогтоомжийг даган мөрдөх арга зүй, татвар төлөгчийн хууль ёсны эрх ашгаа хамгаалах	Танхим болон цахим сургалт Гарын авлагаар хангах Заавар, аргачлал бэлтгэх Программ хангамж
Татварын мэргэжилтэнг мэргэшүүлэх	Татварын чиглэлийн судлаач, татварын мэргэшсэн зөвлөх, татварын улсын байцаагч	Татварын онолын шинэ үеийн хандлагад тулгуурлан хуулийг хэрэгжүүлэх, бүртгэл тайлангийн шинэ арга зүй эзэмших, маргаан хэрэг шийдвэрлэх асуудал, мэргэжлийн англи хэл, олон улсын татварын асуудал	Танхим болон цахим сургалт Гарын авлагаар хангах Заавар, аргачлал бэлтгэх Багаар ажиллах Судалгаа хийх

Хүснэгт 4. Татварын боловсрол олгох үндэсний ерөнхий хөтөлбөр

№	Үйл ажиллагаа	Хамрах хүрээ	Үр дүн	Хамтрах байгууллага
Зорилт 1. Татварын боловсролын үндэсний хөтөлбөрийг боловсруулах судалгаанд суурилсан олон талт түншлэлийг бий болгох				
1.1	Татвар төлөх хандлагыг тодорхойлох судалгааны хөтөлбөр (арга зүй, хамрах хүрээ, аргачлалыг боловсруулж) батлах	Мэргэжлийн олон нийт	Татвар төлөх хандлагын судалгааны аргачлалтай болох	Татварын ерөнхий газар, Боловсролын яам
1.2	Татвар төлөх хандлагын түвшинг үечлэлээр, нөлөөлөх хүчин зүйлсийн зүй тогтлыг томъёолох	Иргэд, олон нийт	Татвар төлөх хандлагын судалгаатай болох	Татварын ерөнхий газар
1.3	Татварын боловсрол, төсвийн тогтвортой байдалд нөлөөлөх аргачлалын дагуу судалгаа мэдээллийн нэгдсэн бааз суурьтай болох		Төсвийн төлөвлөлтөд хэрэглэгдэх бодит мэдээллийн сантай болох	Татварын ерөнхий газар, яам, агентлагууд
1.4	Мэдээллийн санд үндэслэн олон талт түншлэлийн бодлого боловсруулах	Оролцогч/ Сонирхогч талууд	Төрийн чиг үүргээр дамжуулан татварын боловсрол олгох нэгдмэл тогтолцоотой болох	
Зорилт 2. Насан туршийн боловсролын тогтолцоонд татварын боловсрол олгох сургалтын системийг бий болгох, хөгжүүлэх, бэхжүүлэх				
2.1	СӨБ, ЕБС, Их дээд сургууль, МСҮТ, Мэргэжилтэн гэсэн чиглэлд сегментчилж нийгмийн хэрэгцээг тодорхойлох	Сегмент бүрээр	Хэрэгцээгээ сегментчилсэн баримттай болох	Засгийн газар, хэрэгжүүлэгч нэгж, олон нийтийн байгууллага
2.2	Хэрэгцээнд тохирсон насан туршийн боловсрол олгох нийлүүлэлтийн сувгийг үүсгэх		Сегмент бүрийн хэрэгцээг хангахуйц бүтээгдэхүүний нийлүүлэлттэй болох	
2.3	Насан туршийн боловсролын тогтолцоо болгон хөгжүүлэх		Татварын боловсролыг олгох нэгдмэл тогтолцоотой болох	
2.4	Насан туршийн боловсролын тогтолцооны үе шат бүхэнд тохирсон сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүн боловсруулж, хүртээмжийг сайжруулах		Хөтөлбөр, хэрэглэгдэхүүнтэй (загвар, бүтэц) болсон байх	
Зорилт 3. Татварын боловсрол олгох хүний нөөцийг бэлтгэх				
3.1	Татварын боловсрол олгох багш, мэргэжилтнүүдийг сегмент бүрийн онцлогт тохирсон арга зүйгээр чиглүүлэх	Боловсролын салбар	Татварын боловсрол олгох багш бэлтгэгдсэн байх	Татварын ерөнхий газар
3.2	Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаар мэргэжлийн удирдлага арга зүйг нэвтрүүлэх	Олон нийт	Татварын тухай ойлголт мэдлэгтэй татвар төлөгчдийн тоо нэмэгдэнэ. Мэргэжлийн системтэй удирдлага, арга зүйтэй болох	Татварын ерөнхий газар, ТМЗ-ийн нийгэмлэг, ТМЗ хуулийн этгээд, зөвлөхүүд

Хүснэгт 4. Татварын боловсрол олгох үндэсний ерөнхий хөтөлбөр (үргэлжлэл)

№	Үйл ажиллагаа	Хамрах хүрээ	Үр дүн	Хамтрах байгууллага
3.3	Татварын мэргэшсэн зөвлөхүүдийг татварын боловсрол олгох хүний нөөцийн сегмент болгон бэлтгэх	Татвар төлөгчдөд	Мэргэшсэн, бэлтгэгдсэн хүний нөөцтэй болох	ТМЗН, ТМЗ хуулийн этгээд, зөвлөхүүд
Зорилт 4. Татварын боловсрол олгох нэгдсэн платформ бий болгон хүн бүр орон зай, цаг хугацаанаас үл хамааран хүртэх боломжтой байх				
4.1	Татварын боловсрол олгох нэгдсэн платформ үүсгэх	Олон нийт	Татварын боловсролын нэгдсэн платформтай болох	Оролцогч/ сонирхогч талууд
4.2	Нэгдсэн платформ дээр нөлөөллийн мэдээлэл, мэдлэг олгох контентүүдийг бэлтгэж, байршуулах		Олон хувилбарт контентүүд бий болгох	
4.3	Үндэсний татварын албаны ухуулагч дүр бүтээн хөгжүүлэх, нутагшуулах		Брэнд дүртэй болсон байх	
4.4	Татварын боловсрол олгох удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх		Тасралтгүй тогтолцоотой болсон байх	

Жич: Ерөнхий хөтөлбөрийг богино, дунд, урт хугацаагаар нарийвчилсан төлөвлөгөөг оролцогч талуудын оролцоотойгоор гаргаж хэрэгжүүлэх боломжтой.

Үндэсний хэмжээний хөтөлбөрийг гаргаж, оролцогч талуудын оролцоотой төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх нь өргөн хүрээг хамарсан ажил болох тул улс төрийн болон төрийн байгууллагуудын оролцоо, дэмжлэг чухал үүрэгтэй юм. Татвар төлөгчдийн мэдлэг, оролцогч байгууллагуудад итгэх итгэл, улс төрийн оролцоо, оролцогч талуудын оролцоог бий болгоход ямар зохицуулалт хэрэгтэй болох вэ? Мэдлэгийг нэмэгдүүлэх нь татвар төлөгчдөд авлигатай тэмцэх, тэдний эрхийг баталгаажуулах боломжийг хэр зэрэг нэмэгдүүлж чадах вэ? Татварын янз бүрийн мэдлэг нь хуулийг дагаж мөрдөхөд хэрхэн нөлөөлдөг вэ? зэргээр олон зүйл тодорхойгүй байгаа нь татварын боловсролын талаар илүү их судалгаа, бодлогын яриа хэлэлцээ хийх шаардлагатай болохыг харуулж байна.

Дүгнэлт

1. Татварын боловсрол нь татварын мэдлэгт эерэг, чухал нөлөөтэй, татварын мэдлэг нь татварын шударга байдалд чухал, эерэг нөлөө үзүүлдэг, татварын шударга байдал нь татварын хуулийг сахин мөрдөлтөд ихээхэн эерэг нөлөөлөх ба татварын орлого өсөн нэмэгдэхэд эерэг нөлөө үзүүлнэ.
2. Татварын мэдлэг чадвартай мэргэжилтнүүд татварын албанд болон мэргэшсэн үйлчилгээнд ажиллахаас илүү татварын мэдлэг, ёс суртахуун бүхий татвар төлөгчтэй татварын соёл бүрдсэн улс орон байх нь хөгжлийн нэг тулгуур нь гэж үзэж байна. Татварын боловсрол бол татварын соёлыг өөрчлөх, ёс суртахууныг төлөвшүүлэх гол хэрэгсэл юм.
3. Татвар төлөгчдийн татварын мэдлэгийн өнөөгийн байдлыг судлахад судалгаанд

хамрагдсан иргэдийн 38.1% нь маш муу, 52.6% нь муу, 8.1% дунд, 1.2% нь сайн (90.7% муу); татварын талаарх ойлголтыг 73.4% нь хөдөлмөрийн харилцаанд ороод мэддэг болсон, 9.7% нь их, дээд сургуульд сурч байх үедээ анх ойлголт авсан; нийт аж ахуйн нэгжийн 58.0% нь тайлан ирүүлдэг, үүний 23.4% нь татвар ногдох орлоготой гэж тайлагнасан; ХХОАТ-ын ТТ-06 тайланг 14.2% нь гаргасан, үүний 62.2% нь хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх зорилгоор тайлагнасан гэж хариулжээ. Эндээс иргэдийн татварын мэдлэг муу, мэдлэг олгох боловсролын нэгдсэн үр дүнтэй тогтолцоо бүрдээгүй, ААНОАТ ба ХХОАТ-ын хуулийн хэрэгжилтийн хүрээнд татвараа өөрөө тодорхойлон төлөх (хуулийг сахин мөрдөх) нь хангалтгүй, татварын соёл бүрдээгүй байна.

4. Татварын боловсрол нь татварын алба, иргэдийг холбох гүүр тул улс төрийн дэмжлэгтэйгээр өргөн хүрээний оролцогч талуудын хамтын ажиллагааны нэгдэлд төлөвших учиртай. Иймээс татварын боловсролыг оролцогч талуудын оролцоо бүхий нэгдмэл системтэй хөтөлбөрийн дагуу олгох, түүнийг хэрэгжүүлэхэд төрийн бүх талын дэмжлэг, олон нийтийн оролцоо, системтэй хамтын ажиллагаа чухал үүрэгтэй юм.

Санал, зөвлөмж

1. Татварын хуулийг сахин мөрдөхөд татвар төлөгчдийн мэдлэг хангалтгүй байгаа нь судалгааны үр дүнгээр тогтоогдсон. Иймээс мэдлэгтэй татвар төлөгчтэй болохын эхлэл нь иргэний үүргийн биелэлтийг, иргэний эдлэх

эрхтэй холбох, үүргээ хэрэгжүүлж байж төрөөс хүртэх эрхээ эдлэх эрх зүйн зохицуулалт, механизмыг бий болгох (Тухайлбал: ХХОАТ-ын хуулийг иргэний үүргийн хэмжилт, нийгэм-эдийн засгийн хөгжлийн толь гэдгээр харах).

2. Татвараа өөрөө тодорхойлон төлөх тогтолцоог үр дүнтэй, хариуцлагатай болгох чиглэлээр ЭЗХАХБ болон дэлхийн улс орнуудын хүрээнд хийгдэж буй олон янзын судалгааны үр дүн, хэрэгжүүлж буй тэргүүн туршлагаас суралцах, өөрийн орондоо нийцүүлэн хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох, оролцогч талуудын нэгдлийг хангасан нэгдсэн чиг хандлага бүхий бодлого хэрэгжүүлэх.
3. Татварын боловсролыг олгож буй олон улсын тэргүүн туршлагаас өөрийн онцлогт нийцүүлэн нэвтрүүлэх арга хэмжээ авах. Тухайлбал: Япон улс нь “Татварын боловсролыг дэмжих холбоо”, мөн Европын холбооны TAXEDU дижитал платформ гэх мэт сайн туршлагуудаас суралцаж хэрэгжүүлэх нь сайн сайхан нийгмийг цогцлоох үндэс болох юм.
4. Татварын боловсролыг ирээдүйн, өнөөгийн мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх түвшингээр онцлог шинжид нь нийцүүлэн нэгдмэл чиг хандлагаар, системтэй олгох арга зүйн хандлагыг тогтоох буюу сургагч багш, сургалтын материал бэлтгэх хэлбэрээ тодорхойлон бүх нийтийн үйл хэрэг болгох, татварын боловсролыг олгох ерөнхий хөтөлбөрийг богино, дунд, урт хугацаагаар нарийвчилсан төлөвлөгөөг оролцогч талуудын оролцоотойгоор гаргаж хэрэгжүүлэх.

Ашигласан материал

- Chuenjit, P. (2014). The Culture of Taxation: Definition and Conceptual Approaches for Tax Administration. *Journal of Population and Social Studies*, 22(1), 17-34.
- Global Tax Advisers Platform (2019). *Opinion Statement on the OECD Consultation on Draft Report on Tax Morale*.
- Hofmann, E., Hoelzl, E., & Kirchler, E. (2008). Preconditions of Voluntary Tax Compliance: Knowledge and Evaluation of Taxation, Norms, Fairness and Motivation to Cooperate. *Zeitschrift fur Psychologie*, 216(4), 209-217.
- James, S., & Alley, C. (2002). *Tax Compliance, Self-assessment and Tax Administration*. MPRA Paper 26906, University Library of Munich, Germany.
- Mascagni, G. (2020). *Taxpayer education: Why it matters and how research can help*. Retrieved from: <https://www.ictd.ac/blog/taxpayer-education-research/>
- Mukhlis, I., Utomo, S. H., & Soesetio, Y. (2015). The Role of Taxation Education on Taxation Knowledge and Its Effect on Tax Fairness as well as Tax Compliance on Handicraft SMEs Sectors in Indonesia. *International Journal of Financial Research*, 6(4), 161-169.
- OECD (2017). *Tax Certainty: IMF/OECD Report for the G20 Finance Ministers*. Paris.
- OECD & FIIAPP (2015). *Building Tax Culture, Compliance and Citizenship: A Global Source Book on Taxpayer Education*.
- Palil, M. R. (2010). *Tax Knowledge and Tax Compliance Determinants in Self Assessment System in Malaysia*. PhD Thesis, University of Birmingham, Birmingham.
- Татварын Мэргэшсэн Зөвлөхийн Нийгэмлэг (2020). *Монгол Улсын татварын хуулиудын шинэчлэл ба тэдгээрийн үр нөлөөний тухай*. Швейцарийн хөгжлийн агентлагийн захиалгат судалгааны ажил.
- Татварын Мэргэшсэн Зөвлөхийн Нийгэмлэг (2021). *Татварын боловсрол төсвийн тогтвортой байдалд нөлөөлөх нь судалгаа*. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн захиалгат судалгааны ажил.
- Алтанзаяа, Г. (2016). *Татвараа өөрөө тодорхойлон төлөх систем - Татварын боловсролын асуудал*. Улаанбаатар.
- Алтанзаяа, Г. (2020). *Татвар*. Улаанбаатар.
- Монгол Улсын Үндсэн хууль (1992).
- Татварын ерөнхий хууль (2019).
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан - www.1212.mn.